

# ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

2021 · 02 сар | Дугаар 27

## ГАРЧИГ

- 2–3 Бодлогын нийтлэл
- 4–5 Зохицуулалтын мэдээ
- 6–7 Ковид–19 цар тахлын үеийн ББСБ–ын нөхцөл байдал
- 8 Тайлбар ба зөвлөмж
- 9 Финтек ба Регтек
- 10 НОГООН БОНД
- 11–14 Шинэ корона вирус (covid–19)–ын улмаас санхүүгийн салбарт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулахад хэрэгжүүлэх арга хэмжээ
- 15 Олон улсын даатгалын зохицуулагчдын холбооны хурал боллоо
- 16 Санхүүгийн боловсролын ач холбогдол
- 17 Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 онд анхаарах асуудлууд
- 18–19 Европ, төв азийн орнуудын үйл явц ковид–19–ийн үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
- 20 Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

## Хүртээмжтэй санхүү


Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

- 8 Засгийн газрын IV байр, Бага тойруу–3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
- ☎ +976–51–264444
- ✉ press@frc.mn
- 🌐 www.frc.mn
- 📍 Санхүүгийн зохицуулах хороо
- 📍 @FRC\_of\_Mongolia

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар

## НОГООН БОНД

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт **Н.Нарантуяа**



Эрвээхийн дэвэлтийн нөлөө буюу Бразилд эрвээхий далавчаа дэвэхэд 10 хоногийн дараа Техаст торнадо болдгийг бид бүхэн сонсож байсан. Энэ нь өнгөрсөн хугацааны багахан өөрчлөлт ирээдүйд ихээхэн хэмжээний нөлөө үзүүлдгийг батална.

Өнөө үед хүн төрөлхтөн бидэнд тохиолдож буй нэгэн төрлийн эрвээхийн нөлөө бол дэлхийн дулаарал, байгаль орчны эвдрэл, биологийн олон янз байдал алдагдаж эргэх холбоогоор бидний өдөр тутмын амьдралд сөргөөр нөлөөлөх болсон. Тухайлбал уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарлын нөлөөгөөр гадаргын усны түвшин нэмэгдэж, үер усны аюул хүн төрөлхтний амь нас, ахуйд хохирол учруулж, хөрсний бохирдол халдварт өвчин үүсгэж байна.

Иймээс уншигч та сүүлийн үед байгаль эхээ хамгаалах ногоон эдийн засаг, нийгмийн хариуцлага, ногоон санхүүжилт зэрэг үгсийг нэлээдгүй сонсох болсон байх.

Хотжилт, аж үйлдвэр, газар тариалан зэрэг үйл ажиллагааг байгаль орчинд ээлтэйгээр явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд санхүүжилт, хөрөнгө оруулалтын орчин гол хөшүүрэг юм. Учир нь ямар ч бизнес үйл ажиллагаагаа явуулахад санхүүгийн эх үүсвэр шаардлагатай байдаг ба зээлдэгч, хөрөнгө оруулагч нар санхүүжигчийн найдвартай эсэхэд баталгаажуулалт хийдэг. Яг үүн шиг санхүүжилт олгох шалгуурт байгаль орчин, нийгэмд ээлтэй байдлын шалгуурыг бизнесийн байгууллагуудад тавьж, тэднийг байгаль орчин, нийгэмд ээлтэй ажиллах хүчин зүйлийг бүрдүүлнэ. Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулагч та хөрөнгө оруулах шийдвэр гаргахдаа ашгийн өгөөжөө тооцохын хамт тухайн компанийн байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн үнэлгээг хийх юм.

“Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийнхээ 2021 оны дугаарт “Тогтвортой санхүүжилт” буланг шинээр нэмж уншигч танд ногоон эдийн засгийг бий болгоход санхүүгийн зах зээлийн үүрэг оролцооны талаар мэдээлэл хүргэхийг зориллоо. Энэ удаагийн дугаарт “Ногоон бонд”–ын талаар та бүхэндээ хүргэхээр сонгосон ба анхны ногоон бонд нь Насдакийн хөрөнгийн бирж дээр 2015 оны 7 дугаар сард гарч байсан түүхтэй.

Ногоон бонд гэж ногоон төслийг бүхэлд нь болон хэсэгчлэн санхүүжүүлэх ногоон бондын зарчмын дөрвөн шалгуурыг хангасан өрийн хэрэгслийг хэлдэг. Ногоон бондыг уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгалийн нөөц, биологийн олон янз байдлыг хамгаалах, агаарын бохирдлоос сэргийлэх зэрэг байгаль орчинд ээлтэй төсөлд зориулан гаргадаг. Иймээс ногоон бондыг сэргээгдэх эрчим хүч, усны нөөцийг хамгаалах, хог хаягдал, түүний дахин боловсруулалт, агаарын бохирдол, тогтвортой хөдөө аж ахуй, ойжуулалт, уур амьсгалд уян хатан дэд бүтэц байгуулах зэрэг төслүүдэд санхүүжилт босгохоор олон нийтэд санал болгон гаргаж байна. Олон нийтэд санал болгож буй ногоон бондын хувьд Олон улсын хөрөнгийн зах зээлийн холбооноос гаргасан ил тод, нээлттэй байдлыг хангах зарчмыг удирдлага болгодог. Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “СЗХ” гэх/ нь 2020 оны тавдугаар сард Олон улсын санхүүгийн корпорацитай ногоон бондын зах зээлийг хөгжүүлэхэд хууль эрх зүйн орчныг бий болгох санамж бичигт гарын үсэг зурж, идэвхтэй ажиллаж байна.

Ногоон бонд нь стандарт ногоон бонд, ногоон орлогын бонд, ногоон төслийн бонд болон баталгаажсан ногоон бонд гэсэн 4 төрөлтэй. Стандарт ногоон бонд нь ногоон бондын зарчмын дагуу боловсруулагдсан байдаг бол ногоон орлогын бонд нь ногоон төслөөс орж ирэх мөнгөн урсгалаар баталгаа гаргадаг. Ногоон төслийн бонд нь ногоон бондын зарчмын дагуу боловсруулагдаж нэг болон түүнээс олон тооны ногоон төслүүдэд санхүүжилт нь зарцуулагдах ба хөрөнгө оруулагч төслийн эрсдэлийг шууд хариуцдаг. Баталгаажсан ногоон бонд нь ногоон төслөөр барьцаалагдсан бонд ба мөн адил ногоон бондын зарчмын дагуу боловсруулагддаг.

Үргэлжлэл 10–р нүүрт >>

## ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

**Баланс ба орлого үр дүнгийн тайлан** нь байгууллагын үйл ажиллагаатай холбогдох үндсэн санхүүгийн мэдээлэл болох одоогийн нөхцөл байдал, орлого зарлагыг тайлагнадаг. Баланс, орлого үр дүнгийн тайлан хамтдаа байгууллагын цаашдын санхүүгийн эрүүл, тогтвортой байдалд дүн шинжилгээ хийхэд суурь нь болж өгдөг.



*The balance sheet and income statement provide the basic financial information about an institution and its activities. Together, they report on the financial position of the institution and its income and expenditures. Progressive balance sheets and income statements, together with the portfolio report, serve as the foundation for the further analysis of the institution's financial health, performance and viability."*



## БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

### БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН, ТҮҮНИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ БОДЛОГО


#### Хууль, эрх зүйн орчин

2020 оны жилийн эцсийн байдлаар СЗХ–ноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 532 банк бус санхүүгийн байгууллага /цаашид “ББСБ” гэх/ байгаагаас 77 ББСБ нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол гадаадын хөрөнгө оруулалттай 29 ББСБ, олон нийтэд хувьцаагаа санал болгосон 4 ББСБ байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар 14 хуулийн этгээдэд шинээр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 20 ББСБ–ын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 34 ББСБ–ын үйл ажиллагааг түдгэлзүүлж, 9 ББСБ–ын үйл ажиллагааг сэргээлээ.

Санхүүгийн үйлчилгээнд техник технологийг ашиглаж, шинэ төрлийн үйлчилгээ бий болгон, уламжлалт зээлийн үйлчилгээг хялбар, түргэн, шуурхай болгож буй онлайн зээлийн үйлчилгээг 15 ББСБ үзүүлж байна.

ББСБ–ын салбарын эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, харилцагч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, салбарын оролцогчдыг үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 онд нийт 10 журам, зааврыг шинээр болон нэмэлт өөрчлөлт оруулан Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. Тухайлбал,



1. “СЗХ 2020 оны 6 дугаар сарын 29–ний өдрийн 495 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам”–ыг батлуулан, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ–уудыг төрийн цахим төлбөрийн системд холбох зохицуулалтыг бий болгож, Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг ашиглан ББСБ нь төрийн мэдээллээс үнэ төлбөргүйгээр харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг явуулж, үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, И–баримт олгох, харилцагчийн мэдээллийг үнэн зөв нийлүүлэх, хянах боломжийг бүрдүүлээ.
2. СЗХ–ны 2020 оны 12 дугаар сарын 09–ний өдрийн 998 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”–ыг шинэчлэн баталсан. Шинэчлэн баталсан журмын хүрээнд ангиллын нэршлийг олон улсын стандартад нийцүүлж, хугацаа хэтэрсэн өдрөөс хойш иргэн, хуулийн этгээдийн хувьд 30 хүртэл хоногт багтаан эргэн төлөлт хийгдсэн нөхцөлд хэвийн ангилалд бүртгэх, ангилал буурсан активын ангиллыг дээшлүүлэх зэрэг зээлдэгчийн эрх ашгийг хамгаалсан, чанаргүй активт бүртгэгдэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжийг

бүрдүүлсэн чухал зохицуулалтыг бий болгон ажиллаад байна.

3. СЗХ-ны нэг зохицуулалт болох зээлийн батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор СЗХ-ны 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 352 дугаар тогтоолоор “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулж батлуулсан. Ингэснээр иргэд, ЖДҮ эрхлэгчдэд хүргэх батлан даалтын үйлчилгээний хүртээмж нэмэгдэж байгаа юм.

СЗХ-ноос шинэ төрлийн Коронавирус (КОВИД-19)-ын улмаас дотоодын эдийн засаг, санхүүгийн салбарт эрсдэлтэй нөхцөл байдал үүсэж эхлээд байгаа энэ үед санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, харилцагч, зээлдэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

1. УИХ-ын намрын чуулганаар батлагдсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 10.9-т “Банк, эрх бүхий хуулийн этгээдээс цахим хэлбэртэй үйлчилгээнд тухайн банк, эрх бүхий хуулийн этгээдэд данстай, санхүүгийн тогтвортой харилцаа үүсгэсэн этгээдийн бүртгэлтэй баталгаат цахим шуудан, эсхүл техникийн хэрэгсэл, програм хангамж, нууцлалын шаардлага хангасан нууц үг, нууц код, тоон гарын үсэг зэргийг ашиглан гаргасан саналыг банк, эрх бүхий хуулийн этгээд хүлээн авсан бол Иргэний хуулийн 421 дүгээр зүйл, 196.1-т заасантай адилаар хэлцэл хийсэн, гэрээ байгуулсанд тооцно.” гэж тусгаснаар цахим зээлийн гэрээг хүлээн зөвшөөрөх эрх зүйн орчин бүрдээд байна.
2. Цар тахалтай холбогдуулан эдийн засгийн байдал хүндэрч, иргэд аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаа доголдонтой холбогдуулан иргэдийг чанаргүй зээлийн ангилалд шилжүүлэхээс урьдчилан сэргийлж ББСБ-уудад мөрдөгдөж буй “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д нийт 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, үйлчлэлийн хугацааг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэл сунгаад байна.

Өөрөөр хэлбэл, зээлийн хугацааг 90 хоног хүртэлх хугацаанд хэвийн ангилалд ангилах, зээлийн гэрээг 2 болон түүнээс дээш сунгасан тохиолдолд ангилал бууруулахгүй байхаар шийдвэрлэсэн.

3. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 183 дугаар тогтоолын дагуу СЗХ-ны Ажлын албаны даргын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний 3/4654 дугаар албан тоотоор зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудад иргэд аж ахуйн нэгжид олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хойшлуулах хүсэлтийг шийдвэрлэхдээ нэмэгдүүлсэн хүү, торгууль, алданги, ногдуулж, хүүг нэгтгэж тооцох зэргээр зээлдэгчид нэмэлт дарамт үүсгэхгүйгээр, төлбөрийн чадварт нь нийцүүлэн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулахыг мэдэгдэн ажиллалаа.

4. УИХ-аас 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 32 тоот тогтоолоор баталсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай” тогтоолын хавсралтаар өгөгдсөн үүрэг даалгаврын 4-т жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр Зээлийн батлан даалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх, батлан даалтын сангийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай зохицуулалтын бодлого, журамд өөрчлөлт оруулах үүргийг СЗХ-нд өгсний дагуу “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д 2 удаа түр хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулж, батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлэхээр шийдвэрлэв. Журмыг дагаж мөрдсөн өдрөөс хойш 69 зээлдэгчийн 25.0 тэрбум төгрөгийн зээлд 12.2 тэрбум төгрөгийн батлан даалт гаргах хүсэлт ирүүлснээс 41 зээлдэгчийн 15.2 тэрбум төгрөгийн зээлд 6.9 тэрбум төгрөгийн батлан даалт гаргахаар шийдвэрлэсэн байна. Коронавируст халдвар (КОВИД-19)-т цар тахлын үед үйл ажиллагаа нь хүндрэлд орсон нийт 62 аж ахуйн нэгжийн 13.8 тэрбум төгрөгийн батлан даалттай, 26.0 тэрбум төгрөгийн зээлийн гэрээний хуваарьт өөрчлөлт оруулж зээл төлөх хугацааг хойшлуулжээ.

5. СЗХ-ноос ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллаж байгаа бөгөөд цар тахалтай холбогдуулан ББСБ-уудын зээлийн эргэн төлөлт удааширч, үйл ажиллагаа нь доголдож хүндрэл үүссэнтэй холбогдуулан ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг 2022-2023 он хүртэл хойшлуулахаар шийдвэрлэсэн. Тухайлбал, 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1.9 тэрбум төгрөгт хүргэх байсныг 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хүртэл, 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор 2.5 тэрбум төгрөгт хүргэхээр шийдвэрлэлээ.

#### Хамтын ажиллагаа

СЗХ нь хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд ББСБ-ын салбарын эрх зүйн орчинг сайжруулах, олон улсын жишигт нийцүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор бодлого зохицуулалтын чиглэлээр дараах олон улсын байгууллага, холбоодтой хамтран ажиллаж байна.

Олон Улсын Санхүүгийн Корпорацтай “Ногоон санхүүжилтийг хөгжүүлэх” болон “Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн төслийг хамтран хэрэгжүүлэх” харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулж, факторингийн үйл ажиллагааны талаарх гарын авлагыг боловсруулж, харилцагчдад хүргэхээр ажиллаж байна. Мөн Азийн хөгжлийн банктай хамтран “Банк бус санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулах” төслийг хэрэгжүүлж, төслийн хүрээнд эрсдэлд суурилсан хяналт шалгалт, ББСБ-уудыг чадавхжуулах чиглэлээр сургалт зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаад байна.

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ээс хэрэгжүүлж буй “Хүртээмжтэй ногоон санхүүжилт”, “Зохицуулалттай этгээдүүдийн ногоон санхүү эрхлэх чадавх” төслийг тус тус хамтран хэрэгжүүлж, 266 ББСБ-уудаас “Ногоон санхүү” судалгааг авч “Зохицуулалттай этгээдүүдийн ногоон санхүү” сэдэвт сургалтыг зохион байгуулахаар ажиллаж байна.

## ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

### САНХҮҮГИЙН ЛУЙВРААС ТА СЭРГИЙЛЖ ЧАДАХ УУ

– Санхүүгийн луйвар буюу пирамид, понзи схем гэж юу вэ–

Богино хугацаанд их мөнгөтэй болох гэсэн эсвэл мөнгөө өсгөх үүднээс сайтар нягтлалгүйгээр санхүүгийн харилцаанд орсноос хохирогч болсон иргэд, аж ахуйн нэгжийн тоо сүүлийн үед эрс ихэссэн. Зөвхөн нэг тоо дурдахад, санхүүгийн залилан, луйврын шинжтэй гэмт хэргийн улмаас иргэд, байгууллагад учирсан хохирлын хэмжээ 2016 онд 2 тэрбум орчим төгрөг байсан бол 2017 онд 6.4 тэрбум, 2018 онд 9.9 тэрбум, 2019 онд энэ тоо 13 тэрбум төгрөгт хүрч, жил ирэх тусам нэмэгдсээр байна.

Иймээс өндөр өгөөж, ашиг амласан элдэв хөрөнгө оруулалтаар далласан саналыг хүлээж авахын өмнө СЗХ–ноос гаргасан “Санхүүгийн луйвар пирамид болон понзи схем” гарын авлагыг уншихыг зөвлөж байна. Учир нь, хажууд тань чимээгүйхэн гэтэж буй луйвар гэж юу болох, санхүүгийн пирамид, түүний хэлбэрүүд, понзи схемийн нийтлэг шинж, урьдчилан сэргийлэх арга зам, хууль эрх зүйн орчин, хэрхэн таслан зогсоох талаар цогц мэдээлэл багтсан тул залилангийн төрлийн аливаа гэмт хэргээс сэргийлэхэд Таны хөтөч болж чадна. /Үргэлжлэлийг цахим хуудаснаас/

### ХАМТАРСАН СУРГАЛТ БОЛЛОО

Нэгдсэн Үндэсний байгууллагын Терроризмтой тэмцэх хороо, Европын Холбоотой хамтран Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх зорилгоор “Ашгийн бус байгууллагыг терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаахад урвуулан ашиглахтай тэмцэх нь” сэдэвт цахим сургалтыг 2021 оны 02 дугаар сарын 16–17–ны өдрүүдэд зохион байгууллаа.

Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)–ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтаас 2020 онд гарсан. Гэсэн ч цаашид МУТСТ тогтвортой тогтолцоог үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд ФАТФ–ын Зөвлөмж 8 /ашгийн бус байгууллагыг зүй бусаар ашиглахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ/–ыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахад ач холбогдол өгөх энэхүү сургалтад СЗХ–ны албан хаагчид болон хяналт, зохицуулалтад хамаарах мэдээлэх үүрэгтэй этгээдүүд болон холбогдох бусад байгууллагын төлөөлөл хамрагдлаа.




Сургалтаар ФАТФ–ын зөвлөмж, шаардлага, ашгийн төлөө бус байгууллагууд, төрийн бус байгууллагуудын МУТСТ үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, мэдээлэх үүрэгтэй этгээдийн үүрэг хариуцлагын талаар хэлэлцсэн. Мөн ашгийн төлөө бус байгууллагуудын МУТСТ–тэй холбоотой эрсдэлийг үнэлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тогтолцоо, зохицуулалтын арга хэрэгсэл зэргийг хэлэлцсэн үр дүнтэй сургалт боллоо.

### САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ БОЛЛОО

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)–ийн энэ оны нэгдүгээр улирлын ээлжит хурлыг энэ сарын 1–16–ны өдрийн хооронд хоёр үе шаттайгаар зохион байгуулав.

Эхний хурлаар Засгийн газраас хэрэгжүүлэхээр санаачилсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөө”–ний хүрээнд Монгол Улсын эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн саналыг боловсруулж, танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Монголбанкны дэд ерөнхийлөгчөөр ахлуулан байгуулав. Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд СЗХ, Сангийн яам, Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпорац болон Зээлийн батлан даалтын сангийн төлөөлөл орж ажиллав.





Харин энэ сарын 16-ны өдрийн хурлаар эдийн засгийг сэргээх хүрээнд ажлын хэсгээс боловсруулсан ажлын байрыг дэмжих зээл, ипотекийн зээл, репо санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцлээ. Дээрх асуудлын хүрээнд зээлийн батлан даалтын үйл ажиллагааг идэвхжүүлэх замаар аж ахуйн нэгжүүдэд хүүгийн хөнгөлөлттэй зээл олгох, уул уурхайн орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулж эх үүсвэр бүрдүүлэн ажлын байрыг дэмжих болон хөдөө аж ахуйн салбарт хүүгийн хөнгөлөлттэй зээл олгох, Монголбанкнаас хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хэмжээг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын зорилттой уялдуулан репо санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх санал, түүнийг хэрэгжүүлэх арга механизмыг танилцууллаа. Ингээд арга хэмжээний саналыг зөвлөлийн гишүүд дэмжиж, Засгийн газрын хуралдаанд Сангийн яамнаас танилцуулж, Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгчөөр ахлуулсан хамтарсан ажлын хэргийг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавихаар тогтлоо.

### ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ГИШҮҮДИЙН БҮРТГЭЛИЙГ ЦАХИМЖУУЛЖ ЭХЭЛЛЭЭ

Коронавирус /КОВИД-19-/ын халдварт цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулж хөл хорио тогтоогоод нэлээдгүй хугацаа өнгөрсөн ч СЗХ салбартай холбоотой бодлого шийдвэрийг шуурхай тасалдалгүй гаргах, аж ахуйн нэгжүүдийн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг цаг тухай бүрт нь шийдвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулсаар байна.

Тухайлбал, хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/-нд өөрийн хөрөнгө болон гишүүдийн бүртгэлд орсон өөрчлөлтийг ХЗХ-ны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т зааснаар хагас, бүтэн жилээр СЗХ-нд ирүүлдэг байсан. Харин цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулж ХЗХ-дын 72,000 гаруй гишүүний бүртгэлийг 2021 оны 5

дугаар сарын 01-ний өдрийн дотор цахимжуулах ажлыг эхлүүлээд байна.

ХЗХ-дын гишүүдийн бүртгэлийг цахимжуулснаар Улсын бүртгэлийн ерөнхий газар болон төрийн бусад байгууллагуудтай цаашид мэдээлэл солилцох боломж нээгдэхийн зэрэгцээ цаг хугацаа, зардал хэмнэх олон талын ач холбогдолтой.

### САНХҮҮГИЙН САЛБАРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТОЙМ МЭДЭЭЛЛЭЭ ТАНИЛЦУУЛЛАА

СЗХ-ноос санхүүгийн салбарын 2020 оны жилийн эцсийн тойм мэдээллийг танилцуулсан хэвлэлийн бага хурал боллоо. СЗХ нь зохицуулалт хяналтынхаа чиг үүргийн хүрээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар 3,260 зохицуулалттай этгээд, 2,473 даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллалаа. Зохицуулалттай этгээдүүдийг салбарын ангиллаар харвал үнэт цаасны зах зээлд бүртгэлтэй 315 ХК, 276 мэргэжлийн оролцогчид, даатгалын зах зээлд нийт 319 даатгалын компани, мэргэжлийн оролцогчид, аудитор, 532 ББСБ, 249 ХЗХ, 167 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч 429 хувь хүн, хуулийн этгээд, тэдгээрийн 973 салбар тус тус үйл ажиллагаа явуулж байна. /Үргэлжлэлийг цахим хуудаснаас/

### ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ХУГАЦААГ ХОЙШЛУУЛЛАА

СЗХ-ны ээлжит хоёрдугаар хуралдаанаар ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх хуваарийг хойшлуулахаар шийдвэрлэлээ.

## БАЙР СУУРЬ

## КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН ББСБ-ЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

ББСБГ-ын мэргэжилтэн Х.Тэмүүлэн

### Коронавируст (КОВИД-19) цар тахалтай холбогдуулан иргэд, харилцагч руу чиглэсэн ямар хууль, эрх зүйн орчин бүрдүүлсэн бэ?

“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн 10.9-т зааснаар цахим зээлийн гэрээг хүлээн зөвшөөрөх эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд ингэснээр харилцагч заавал биеэр очин зээлийн гэрээ байгуулах шаардлагагүй болж байгаа юм.

### Цар тахлын үед эдийн засаг хүндэрч, иргэд аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаа доголдож буй энэ үед зээлдэгчдийн эрх ашгийг хамгаалах бодлогын ямар арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бэ?

Цар тахлын үед ард иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа доголдсонтой холбогдуулан иргэдийг чанаргүй зээлийн ангилалд шилжүүлэхээс урьдчилан сэргийлж ББСБ-уудад мөрдөгдөж буй активыг ангилах журамд нийт 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, үйлчлэлийн хугацааг сунган ажиллаад байна. Өөрөөр хэлбэл зээлдэгчийн зээлийн чанар муудахад зээлийн мэдээллийн санд ангилал бууруулах эрсдэлээс хамгаалж буй зохицуулалт юм. Үүний үр дүнд 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 234.8 мянган зээлдэгчээс 291.9 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлснээс, 267 ББСБ үйл ажиллагаа нь тасалдаж хүндрэл үүссэн 230.5 мянган зээлдэгчийн 257.6 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт орсон байна.

### Зээлийн төлбөр хойшлуулах хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн бэ?

СЗХ-ноос Зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ууд Зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хойшлуулах хүсэлтийг шийдвэрлэхдээ нэмэгдүүлсэн хүү, торгууль, алданги, ногдуулж, хүүг

нэгтгэж тооцох зэргээр зээлдэгчид нэмэлт дарамт үүсгэхгүйгээр, төлбөрийн чадварт нь нийцүүлэн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулахыг мэдэгдээд байна.

### “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д орсон өөрчлөлтийн үр дүнгийн талаар мэдээлэл өгнө үү?

Батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлэхээр журамд 2 удаа түр хугацаанд нэмэлт өөрчлөлт оруулсан. Тодруулбал, нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдэд гаргах зээлийн батлан даалтын хэмжээ нь ББСБ-аас авах тухайн зээлийн 60 хүртэл хувь буюу Сангийн өөрийн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй байсныг 3 хувь болгон бууруулж олон зээлдэгчид батлан даалт гаргах боломж бүрдүүлсэн. Батлан даалттай зээл авсан зээлдэгчдийн тоог өмнөх оны мөн үетэй харьцуулж үзэхэд 1.2 хувиар өсөж 416-д хүрсэн.

### Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд орсон өөрчлөлтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?

Ер нь “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” нь ББСБ болон зээлдэгчдэд маш чухал эрх зүйн баримт бичиг юм. Энэхүү журмын хүрээнд ББСБ нь зээл, факторинг, авлага зэргийг хугацааны үзүүлэлтийн хувьд ангилж, эрсдэлийн санг байгуулах бөгөөд ББСБ-ын зээлд байгуулсан эрсдэлийн сангийн зардлыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу албан татвар ногдох орлогоос хасаж тооцдог. Харин зээлдэгчийн хувьд зээлийн ангиллаа тодорхойлох, зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлийн ангилалд хамрагдахаас урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Анх СЗХ-ны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125

дугаар хамтарсан тушаалаар “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг баталж байсан бөгөөд тус журам нь 2021 оны 01 дүгээр сар хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан.

СЗХ-ноос зээлдэгчдийн эрх ашгийг хамгаалах, зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор СЗХ-ны 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 998 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг шинэчлэн баталсан.

Харин дэлхий нийтэд тархаад буй цар тахал Коронавирус (КОВИД-19) дотоодод тархаж бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолоор “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” баталсан. Энэхүү тогтоолын 8-д ББСБ, ХЗХ-ноос иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацааг зээлдэгчийн хүсэлтийг харгалзан нэмэгдүүлсэн хүү, торгууль, алданги тооцохгүйгээр зээлдэгчид ямар нэгэн дарамт үүсгэхгүй байхаар төлбөрийн чадварт нь нийцүүлэн гэрээнд өөрчлөлт оруулах зохицуулалтын арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд авч хэрэгжүүлэхийг зөвлөсөн. Энэ ажлын хүрээнд дээрх СЗХ-ны 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1020 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын зээл, факторингийн ангилалд өөрчлөлт оруулж, 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэл мөрдөхөөр шийдвэрлэсэн. Уг шийдвэрийн хүрээнд 90 хоногоор хугацаа хэтэрсэн бол хэвийн зээлд, хугацаа хэтэрсэн зээлийн ангилалд 1-90 хүртэл хоног байсныг 91-150 хоног, чанаргүй зээлийн ангилалд 151 хоногоос дээш хугацаанд хугацаа хэтэрсэн тохиолдолд бүртгэж, зээлдэгчийн хүсэлтийн дагуу зээлийн гэрээг 2 болон

түүнээс дээш сунгасан тохиолдолд зээлийн ангилал бууруулахгүй байхаар зохицуулсан.

**(КОВИД-19) цар тахалтай холбогдуулан чанаргүй активын хэмжээг нэмэгдэхээс сэргийлэн авч буй арга хэмжээний талаар дурдана уу?**

Монгол Улс бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагаа доголдож, зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хойшлуулах, нөгөө талаас салбарын чанаргүй активын хэмжээ нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх зохицуулалтыг зайлшгүй өөрчлөх нөхцөл бүрдсэн.

Иймд СЗХ зээлдэгчдийн зээлийн ангилал буурч чанаргүй ангилалд бүртгэгдэх, салбарын чанаргүй активын хэмжээ нэмэгдэхээс урьдчилан сэргийлж дээр дурдсан ББСБ-дад мөрдөгдөж буй “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д тухай бүр өөрчлөлтийг оруулж, бизнесийн үйл ажиллагаа нь доголдож зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлөлт хийхэд хүндрэл үүссэн зээлдэгчийн хүсэлтийн дагуу зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлөлтийн хугацааг сунгаж, нэмэгдүүлсэн хүү, алданги тооцохгүйгээр аливаа чирэгдэл, хүндрэл үүсгэхгүйгээр

шийдвэрлэхийг ББСБ-уудад үүрэг болгосон. Үүний үр дүнд 2020 онд нийт 193.3 мянган зээлдэгчээс 257.4 тэрбум төгрөгийн зээлийн гэрээндээ өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлсэн бөгөөд 265 ББСБ үйл ажиллагаа нь тасалдаж хүндрэл үүссэн 189.5 мянган зээлдэгчийн 226.2 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, үндсэн төлбөр болон хүүг төлөх хугацааг сунгасан байна.

СЗХ-ноос бүх нийтийн бэлэн байдлын зэргийн үед зээлдэгчдийн нөхцөл байдал, салбарын активын чанарын үзүүлэлтэд тухай бүр судалгаа, шинжилгээ хийх үүднээс зээлийн хүндрэл үүссэн зээлдэгчдийн мэдээллийг долоо хоног бүр авч ажиллаж байна.



## ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

### БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН АКТИВЫГ АНГИЛАХ, АКТИВЫН ЭРСДЭЛИЙН САН БАЙГУУЛЖ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Төр засгаас явуулж буй хууль, эрх зүйн шинэтгэлийн хүрээнд шинээр батлагдсан хууль тогтоомжтой нийцүүлэх мөн санхүүгийн зах зээлийн олон улсад дагаж мөрдөж буй стандарттай нийцүүлэх зорилгоор “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг СЗХ-ны 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 998 дугаар тогтоолоор шинэчлэн баталлаа.

Тус журмаар банк бус санхүүгийн байгууллагын зээл, факторинг, үнэт цаас (Монголбанкны үнэт цаас, 1 жил хүртэлх хугацаатай Засгийн газрын үнэт цааснаас бусад үнэт цаас), өмчлөх бусад хөрөнгө, авлагыг ангилах, тэдгээрт учирч болзошгүй алдагдлаас хамгаалах эрсдэлийн санг байгуулж, зарцуулахтай холбоотой харилцааг зохицуулах юм.

Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1-т “Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална”, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Нөөцийн сан, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг СЗХ-ноос тогтоосон журмын дагуу хангаж биелүүлнэ” гэж заасны дагуу тус журмыг шинэчлэн батлах хууль зүйн үндэслэл байсан бол дараах практик шаардлага үүссэн. Үүнд:

Олон улсад мөрдөгдөж буй стандарттай нийцүүлэх. Жишээ нь: “Хугацаа хэтэрсэн” гэдэг ангиллыг “Анхаарал хандуулах” гэсэн ангилал болгосон;

Үндэслэл: Олон улсад ихэвчлэн “Special Mention” эсвэл “Watch” буюу “Анхаарал хандуулах” гэсэн нэршлийг ашиглаж байна. Хугацаа хэтэрсэн гэх нэршлийг хэвийн төлөлттэй зээлээс бусад зээлийг нэрлэхэд ашиглаж байна. Иймд олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор анхаарал хандуулах гэж нэрлэх нь зохимжтой гэж үзсэн.

- Хугацаа хэтэрсэн өдрөөс хойш иргэн, хуулийн этгээдийн хувьд 30 хүртэл хоногт багтаан эргэн төлөх боломжтой талаар ББСБ-ын зүгээс дүгнэвэл уг зээлийг хэвийн ангилалд бүртгэх боломж бий болгосон;

Үндэслэл: Одоо 2015 мөрдөгдөж байгаа журмаар ББСБ-ууд 1-89 хоног төлбөр төлөх хугацаа хэтэрвэл ангилал бууруулах боломжтой байдаг. Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт-9 /СТОУС-9/-д төлбөр төлөх хугацаа 30-аас олон хоног хэтэрсэн бол зээлийн эрсдэл өснө гэсэн няцаагдах таамаглалыг дэвшүүлж, санхүүгийн хөрөнгийг дараагийн шатлалд оруулж, таамагласан зээлийн алдагдлыг хүлээн зөвшөөрнө гэж заасан.

- Ангилал буурсан активыг ангилал дээшлүүлэх тухай зүйл заалт оруулсан.

Үндэслэл: Өмнөх журамд тухайлан зохицуулсан зүйл заалт байхгүй бөгөөд ББСБ-ууд банкны зарчмыг үндэслэн ангилал дээшлүүлж байсан тул энэ зүйл заалтыг шинээр нэмж оруулсан.

1. Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг анх СЗХ-

ны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125 дугаар хамтарсан тогтоолоор баталж байсан бөгөөд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай холбоотойгоор Монгол Улсын засгийн газраас бүх бэлэн байдлын зэрэгт шилжсэн. Энэхүү нөхцөл байдлын улмаас эдийн засгийн идэвхжил саарч, иргэд, аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаа алдагдах, орлого тасалдах, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй байгааг харгалзан санхүүгийн салбарт учирч буй эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хадгалах зорилгоор цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэх шаардлага бий болсон.

- Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 183 дугаар “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын 8 дахь заалтаар “Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршооноос иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацааг зээлдэгчийн хүсэлтийг харгалзан нэмэгдүүлсэн хүү, торгууль, алданги тооцохгүйгээр зээлдэгчид ямар нэгэн дарамт үүсгэхгүй байхаар төлбөрийн чадварт нь нийцүүлэн гэрээнд өөрчлөлт оруулах зохицуулалтын арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд авч хэрэгжүүлэхийг Монголбанк (Б.Лхагвасүрэн), СЗХ (Д.Баярсайхан)-д тус тус зөвлөсүгэй” гэсний дагуу Дэлхий нийтийг хамарсан цар тахал “КОВИД-19/-тай холбогдуулан эдийн засгийг дэмжих арга хэмжээний хүрээнд банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмаар холбогдох зохицуулалтыг хийх зайлшгүй шаардлага бий болсны дагуу шинэчлэн баталсан болно.

“Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр дагаж мөрдөх бөгөөд энэхүү журам хэрэгжсэнээр ББСБ-уудын зээл, факторинг, үнэт цаас (Монголбанкны үнэт цаас, 1 жил хүртэлх хугацаатай Засгийн газрын үнэт цааснаас бусад үнэт цаас), өмчлөх бусад хөрөнгө, авлагыг ангилах, тэдгээрт учирч болзошгүй алдагдлаас хамгаалах эрсдэлийн санг байгуулж, зарцуулах эрх зүйн орчин сайжирна.

## ФИНТЕК БА РЕГТЕК

### ИХ ӨГӨГДӨЛ БУЮУ “BIG DATA”

“Их өгөгдөл” гэдэг нь ерөнхийдөө уламжлалт арга барилыг ашиглан боловсруулахад хэцүү эсвэл бүр боломжгүй их хэмжээний, нарийн төвөгтэй өгөгдлийг хэлнэ. Хэдийгээр дүн, шинжилгээ гаргахад зориулж их хэмжээний мэдээллийг олж авах, хадгалах үйл ажиллагаа эрт үеэс эхэлсэн ч 2000–аад оны эхээр салбарын шинжээч Даг Лэйни “их өгөгдөл” гэсэн ойлголтыг гурван V–г ашиглан томъёолсноор түгээмэл ашиглагдах болсон.

**Volume буюу Хэмжээ** – Байгууллагууд өгөгдлийг өдөр тутмын үйл ажиллагаа, ухаалаг төхөөрөмжүүд, үйлдвэрийн тоног төхөөрөмж, олон нийтийн сүлжээ зэрэг төрөл бүрийн эх үүсвэрээс олж авдаг. Өгөгдлийн хэмжээ нь их байх тусам түүнийг ашиглан гарах үр дүн сайн байдаг. Иймээс их өгөгдлийн хувьд хэмжээ нь чухал үзүүлэлт болдог.

**Velocity буюу Хурд** – Интернет хөгжихийн зэрэгцээ байгууллагууд өмнө байгаагүй хурдтайгаар мэдээлэл, өгөгдлийг хүлээн авч байгаа тул цаг тухайд нь зохицуулж байх ёстой. Тэд өмнө дурдсан олон тооны эх үүсвэрээс байнгын мэдээлэл, өгөгдөл хүлээн авч байдаг.

**Variety буюу Төрөл** – Өгөгдөл нь энгийн тоон мэдээлэл зэрэг бүтэцлэгдсэн хэлбэрээс текст, и–мэйл, дүрс бичлэг, аудио зэрэг бүтэцлэгдээгүй зэрэг янз бүрийн хэлбэртэй байдаг. Өмнө нь ихэнх програмын ашиглах боломжтой цорын ганц мэдээлэл нь хүснэгт, мэдээллийн сан байсан бол өнөөдөр и–мэйл, зураг, бичлэг зэргээс өгөгдлийг ялгаж, ангилах боломжтой болсон байна.

#### Яагаад их өгөгдлийг ашиглах нь чухал вэ?

Их өгөгдлийн гол ач холбогдол нь хэдий хэмжээний өгөгдөл байгаадаа биш яаж ашиглахдаа байдаг. Зардал бууруулах, цаг хугацаа хэмнэх, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, ухаалаг шийдвэрийг их өгөгдөлд байршуулсан дурын өгөгдлийг ашиглан гаргах боломжтой. Байгууллагууд их өгөгдлийг өндөр хүчин чадалтай шинжилгээний аргатай хослуулан:

- Үйл ажиллагааны явцад гарсан алдаа, асуудлын шалтгааныг бодит цагийн горимд тодорхойлох,
- Хэрэглэгчийн хэрэглээний зуршилд үндэслэн үйл ажиллагааг тохируулах,
- Бүх эрсдэлийн багцыг хэдхэн минутын дотор дахин тооцоолох,
- Луйврын шинжтэй үйлдлийг байгууллагад нөлөөлөхөөс өмнө илрүүлэх зэргээр ашиглаж байна.

Нийлүүлэлтийн сүлжээний бизнест их өгөгдлийг ашиглах нь ямар давуу талуудтай вэ гэдгийг мэдээллийн цогц системийн судалгааны байгууллага болох “Oodles”-ийн судалгаанаас харвал үйлдвэрлэгчдийн хувьд зардлыг бууруулах, мөн үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээг илүү нарийн тодорхойлох боломжийг олгодог байна.



Эх сурвалж: <https://erpsolutions.oodles.io/>

#### Хэн их өгөгдлийг ашиглаж болох вэ?

Их өгөгдлийг банк, санхүүгээс эхлээд эрүүл мэндийн зэрэг бүхий л салбарт ашиглах боломжтой. Жишээлбэл:

Үйлдвэрлэл – Их өгөгдлийг ашигласнаар бүтээгдэхүүний чанарыг сайжруулахын зэрэгцээ хаягдлыг хамгийн бага түвшинд байлгах, үйлдвэрлэлийн шийдвэрийг хурдан гаргах зэргээр ашигладаг.

Төрийн байгууллагууд – Өөрсдийн их өгөгдөлд дүн шинжилгээ хийх, ашиглах боломжтой болсон тохиолдолд инженерийн шугам сүлжээг удирдах, замын түгжрэлийг арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг чухал нөлөөтэй. Гэсэн хэдий ч мэдээллийн ил тод байдал, нууцлалын асуудлыг харгалзан үзэх шаардлагатай болдог.

Банк, санхүүгийн байгууллагууд – Харилцагчдын хэрэгцээг тодорхойлох, тэдний сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхээс гадна эрсдэл болон луйврыг багасгах, зохицуулалтыг дагаж мөрдөхөд ашигладаг.

**Их өгөгдлийн сул талууд.** Хэдийгээр их өгөгдөл нь олон давуу талыг бий болгодог ч зарим хүндрэл бэрхшээлийг дагуулдаг байна. Дата судалгааны “AtScale” компанийн жил бүр явуулдаг “Big data & Analytics Maturity” судалгааны 2020 оны дугаараас харахад хамгийн түгээмэл тулгардаг асуудлууд нь их өгөгдлийг бүрэн хүчин чадлаар нь ашиглах мэргэжилтнүүдийн хомс байдал, дата засаглал, зардал, аюулгүй байдал зэрэг байсан байна.



## ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

## НОГООН БОНД

» Эхлэл 1-р нүүрт

**Ногоон бондын зарчим гэж юу вэ?**

Ногоон бондын зарчим нь нэг талаас хөрөнгө оруулагч нарт ногоон бондын хөрөнгө оруулалтын байгаль орчны нөлөөллийг үнэлэхэд шаардлагатай мэдээллээр хангахад дэмжлэг үзүүлэх, нөгөө талаас андеррайтерт арилжааны хэлцэл хийхэд зах зээлд ил тод мэдээллийг бий болгоход тусалдаг.

Ногоон бондын зарчим нь санхүүжилтийн зориулалт, төслийн үнэлгээ, удирдлага, хамгийн чухал хэсэг болох тайлагнал, ил тод байдал гэсэн бүлгүүдээс бүрддэг. Тайлагналын хувьд ногоон төслийн явцыг үйл ажиллагааны тайландаа жил бүр тусгана. Ингэхдээ гүйцэтгэлийн чанарын болон тоон үзүүлэлтүүдийг ашиглахыг санал болгодог. Түүнчлэн санхүүжигчийн удирдлагыг байгаль орчны аудиторор хянуулахыг зөвлөдөг.

Хөгжиж буй эдийн засагтай орнуудад тус бондын арилжаа жил бүр нэмэгдэж байгаа нь Олон улсын санхүүгийн корпорацаас гаргасан “Хөгжиж буй улс орнуудын ногоон бондын тайлан”-д тус өрийн хэрэгслийн арилжаа 2019 онд өмнөх оноос 21 хувиар нэмэгдсэнээр гэж тайлагнаснаас харагдана.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө хүн төрөлхтний аж байдалд хэдийнээ нөлөөлж эхэлсэн тул нийгмийн хэрэгцээг даган аж ахуй нэгжүүд ногоон төслүүдийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулагч нар түүнд хөрөнгө оруулах ухамсар нэмэгдэж байгаа тул ногоон бондын эрэлт, нийлүүлэлт өсөх хандлагатай байна.

*Эх үүсвэр: ICMA, Green bond principles, June 2018*

## СУДЛААЧИЙН ИНДЭР

### ШИНЭ КОРОНА ВИРУС (COVID-19)-ЫН УЛМААС САНХҮҮГИЙН САЛБАРТ ҮҮСЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

*Гүйцэтгэсэн: Н.Нарантуяа, Б.Батчимэг, А.Бадамсүрэн, А.Мөнгөнсаран, Б.Батболд, Б.Тэргэл, А.Нинжин, Б.Дөлгөөн, О.Бямбасүрэн, Ч.Билгүүн, Д.Лхагвасүрэн*



Судалгааны товхимолыг дэлгэрэнгүй үзэх холбоос

#### ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны зорилго нь шинэ корона вирус (COVID-19)-ын улмаас Монгол Улсын санхүүгийн зах зээлд үүсэж болох эрсдэлийг шуурхай илрүүлэх, урьдчилан сэргийлэх бодлогын санал боловсруулахад оршино. 2020 оны эхээр улс орон даяар тархаж эхэлсэн шинэ төрлийн корона вирус нь дэлхийн хүн амд хурдацтай тархан иргэдийн эрүүл мэнд, улс орнуудын эдийн засагт томоохон эрсдэлийг үүсгээд байгаа билээ. Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийг 2009 оны хямралаас хойших хамгийн том уналт, бууралт хүлээж байна хэмээн олон улсын шинжээчид таамаглаж эхэлсэн бөгөөд улс орнууд халдварын тархалтыг зогсоох үүднээс хөл хорио тогтоон, эдийн засаг, бизнесийн олон салбарын үйл ажиллагаа тасалдаж эхлээд байна. Халдвар тархсанаас сар гаруй хугацаа өнгөрөхөд манай улсын санхүүгийн зах зээлд онцлох өөрчлөлт гараагүй байна. Гэсэн хэдий ч вирусийн тархалт, хөл хориог даган эдийн засаг, зах зээлд тодорхой бус байдал үүссэн өнөө үед санхүүгийн салбарт чанаргүй зээлийн хувь хэмжээ нэмэгдэх, иргэд, аж ахуй нэгжийн төлбөрийн дарамт ихсэх, хөрөнгийн зах зээлд хувьцаагаа арилжаалж буй нээлттэй компаниудын үйл ажиллагаанд эрсдэл учрах, түүнийг даган хөрөнгийн зах зээлийн онцлох үзүүлэлтүүд буурах, даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт саарах зэрэг эрсдэлүүд санхүүгийн зах зээлд хүлээгдэж байна. Иймд халдварт өвчний тархалт, эдийн засгийн тодорхой бус байдлаас үүдэх эрсдэлийн зардлыг хамгийн бага байлгахад төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, иргэд, олон

нийтийн хариуцлагатай үйлдэл зайлшгүй чухал юм.

Жич: Энэхүү судалгааны ажил нь корона вирусийн тархалтын эрчимжилтийн эхэн үед боловсруулагдсан буюу судалгаанд ашиглагдсан мэдээлэл нь өвчлөл эхэлж байх үеийн мэдээлэлд суурилсан болно.

#### УДИРТГАЛ

2019 оны 12 дугаар сард Хятадын Хубэй мужийн Ухань хотод “Шинэ төрлийн корона вирусээс үүсэлтэй уушгины хатгалгаа” өвчин анх илэрч, халдварлах нөлөө ихтэйн улмаас хүмүүсийн шилжих хөдөлгөөнөөр дамжин дэлхийн бусад улс орнуудад 2020 оны 01 дүгээр сараас эхлэн хурдтай тархан цар тахлын хэмжээнд хүрээд байгаа билээ. Дэлхийн хэмжээнд хамарсан халдварт өвчлөлт нь дан ганц иргэдийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулах зогсохгүй улс орнуудын эдийн засгийн үйл ажиллагаанд эрсдэл учруулах нөлөөтэй юм.

Цар тахлын нөлөөгөөр бизнес эрхлэгч, үйлдвэрлэгч, аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааны тасралтгүй байдал доголдох, зах зээлийн бүтээмж буурах, ажилгүйдлийн түвшин өсөх зэрэг эрсдэлүүд үүсэж байдаг. Түүнчлэн эдийн засаг, зах зээлийн орчныг даган санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал алдагдах, хөрөнгийн хөрвөх чадвар буурах, системийн хэмжээний эрсдэлүүд тохион удаан хугацаанд үргэлжлэх хямралыг өдөөх боломжтой юм. Шинэ төрлийн корона вирусийн дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлд үзүүлэх нөлөө өндөр байгаа бөгөөд дэлхийн хоёр дугаар дайны

дараагаар тохиосон их хямрал, 2009 онд тохиосон санхүүгийн зах зээлийн хямрал зэрэг томоохон хямралуудаас ч илүү гүнзгий нөлөөтэй байж болзошгүй талаар олон улсын судлаачид, эдийн засагчид таамаглал, тооцооллыг боловсруулж байна.

Вирусийн тархалтаас шалтгаалсан энэхүү хямралаас ард иргэдийнхээ амь нас болон ирээдүйн амьдралын чанар аль алиныг нь хамгаалах томоохон сорилт бодлого гаргагчдын өмнө тулгараад буй энэхүү үед тус өвчний дэгдэлт дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээл болон СЗХ-ны зохицуулалтын салбарууд болох хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, ББСБ-ын салбар, ХЗХ-ны салбарын хувьд үзүүлж буй нөлөөг цаг тухай бүр үнэлэх, дэлхийн бусад улс орнууд эдийн засаг, санхүүгийн зах зээлийг хамгаалах чиглэлд бодлогын ямар байр суурьтай оролцож буйг судлах, өвчлөлөөс үүдэн зохицуулалтын салбаруудад үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд, тэдгээрийн хөрөнгө оруулагчид, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааны ажил нь дөрвөн бүлгээс бүрдэх бөгөөд дараагийн бүлэгт халдварт өвчлөл болон онцгой нөхцөл байдлын үед улс орнууд тохиосон хямралыг хэрхэн даван туулсан туршлагыг, гуравдугаар бүлэгт манай улсын санхүүгийн зах зээлд халдварт өвчлөлийн үзүүлж буй нөлөө, дөрөвдүгээр бүлэгт үүсээд буй сөрөг нөлөөллөөс зах зээлийн оролцогчдыг хамгаалах чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээний саналын талаар тус тус тусгасан. Мөн халдварт өвчлөлийн үеэр зах зээлийн оролцогчид, бизнесийн байгууллагуудад үйл ажиллагаандаа мөрдөх зөвлөмжийг боловсруулсан.



## ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕД ХЯМРАЛЫГ ДАВАН ТУУЛСАН УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА

Улс орон бүр өөрсдийн онцлогт тохируулан халдварт өвчин гарсан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, бэлэн байдлын стратеги, төлөвлөгөөг боловсруулдаг. Энэхүү бодлогын баримт бичигт санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахын тулд эрх бүхий байгууллагууд хэрхэн уялдаа холбоотой ажиллаж, ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар тусгадаг. Мөн зарим улс орнуудын хувьд халдварт өвчин гарсан үед мөрдөгдөх зөвхөн санхүүгийн байгууллагуудад зориулсан бизнесийн тогтвортой, тасралтгүй үйл ажиллагааг хангах төлөвлөгөөг урьдчилан боловсруулсан байна. Үүнээс гадна, улс орнууд системийн нөлөө бүхий санхүүгийн байгууллагууддаа бэлэн байдлын үнэлгээг гарган эрсдэлээс урьдчилан сэргийлдэг. Тухайлбал Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын Холбооны нөөцийн банк халдварт өвчний үед санхүүгийн байгууллагуудад тогтвортой үйл ажиллагаа явуулах чадамж буй эсэхийг тодорхойлох зорилгоор бэлэн байдлын үнэлгээг томоохон 15 банкны хүрээнд гаргасан. Мөн үндэсний хэмжээнд төдийгүй бизнесийн байгууллагууд эдийн засгийн

огцом савлагааны үеэр ашиглах эрсдэлийн санг байгуулдаг жишиг олон улсад түгээмэл байна.

### Шинэ корона вирус гарсантай холбоотойгоор улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Корона вирус гарсантай холбоотойгоор дэлхий дахинд улсын болон хувийн хэвшлийн байгууллагууд бизнесийн тогтвортой үйл ажиллагааг хангах төлөвлөгөөг яаравчлан хэрэгжүүлж байна.

**Сингапур:** Сингапурын Худалдаа аж үйлдвэрийн яамны дэргэдэх хуулийн зөвлөх төрийн байгууллага болох “Энтерпрайз Сингапур” нь бизнесийн тогтвортой үйл ажиллагааг хангах төлөвлөгөөг боловсруулах гарын авлагыг гаргасан. Тус гарын авлагад корона вирустэй холбоотой бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг хянах менежерийг томилох зөвлөмжийг өгчээ. Мөн ахлах менежерүүдээс гадна харилцаа холбоо, хүний нөөц, үйл ажиллагаа хариуцсан ажилтнуудын залгамж халааг төлөвлөхийн ач холбогдлыг тус гарын авлагад ихээхэн онцлов. Үүнээс гадна, онцгой нөхцөл байдалд ажиллах багийг байгуулж, тэдгээрийн боловсон хүчнийг бүх цаг үед тусгаарлахыг бизнесийн байгууллагуудад зөвлөсөн байна.

Сингапурын хувийн даатгалын компани “AiA” нь өөрийн 1.4 сая даатгуулагчдаа корона вирусийн даатгалд үнэгүй хамруулах болсноо мэдэгдсэн. Харин шинэ даатгуулагчид 02 дугаар сарын 17–ноос 7 дугаар сарын 31–ний өдрийн хооронд үнэгүй хамрагдах боломжтой. Даатгалын үйлчлэх хугацаа нь энэ оны 12 дугаар сарыг дуустал байх бөгөөд энэхүү тусгай нөхцөл нь \$1000–ын нэг удаагийн төлбөр, эмнэлэгт хэвтэх, коронавирусийн өвчний улмаас нас барсан тохиолдолд \$25000–ын нөхөн төлбөр олгохоор заажээ. Энэ арга хэмжээ нь тус компанийн нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагын хүрээнд хийж буй ажил ажээ.

**Хонконг:** Хонконг улсын зохицуулагч байгууллагууд орон сууцны болон кредит картын зээлээ төлөхөд бэрхшээлтэй байгаа иргэдэд онцгой анхаарал хандуулж ажиллах талаар санхүүгийн байгууллагуудад зориулсан удирдамж гаргасан. Мөн тус улсын эрх баригчид Жижиг, дунд үйлдвэрлэл /цаашид “ЖДҮ” гэх/ эрхлэгчдэд бага хүүтэй зээл олгох, вирусийн эсрэг тэмцэх амны хаалт үйлдвэрлэдэг болон бусад эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг компаниудад шинээр данс нээх үйл ажиллагааг эрчимжүүлэх, санхүүгийн үйлчилгээний шимтгэлээс чөлөөлөх үйл

ажиллагааг хэрэгжүүлэх юм.

Бослого үймээн, коронавирусийн тархалтын улмаас хүнд байдалд орсон эдийн засгаа аврахын тулд Хонконгийн засаг захиргаа 18-аас дээш насны иргэн бүрт \$1200 тараах ба нийт 120 тэрбум Хонконг доллар (\$15.4 тэрбум) зарцуулагдана. Энэхүү тэтгэмжид Хонконгийн байнгын оршин суугч 7 сая орчим хүн хамрагдахаар болжээ. 2019 оны 3 дугаар улирлаас эхэлсэн санхүүгийн хямралын улмаас тус хот сүүлийн 15 жилийн хугацаанд анх удаа төсвийн алдагдалд орсныг сангийн сайд Пол Чан мэдэгдсэн байна. Нөхцөл байдал цаашид улам муудаж, 2021 оны санхүүгийн жил дуусахад Хонконгийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 4.8 хувиар буурах төлөвтэй байгааг тэрээр анхааруулжээ. Бэлэн мөнгө тараахаас гадна Хонконгийн эрх баригчид татвараас хөнгөлөх, бага орлоготой иргэдийн орон сууцны нэг сарын түрээсийн төлбөрийг чөлөөлөх, амьжиргааны түвшин доогуур 200,000 өрхөд нэг удаагийн тэтгэмж олгохоор болжээ.

**Вьетнам:** Вьетнам улсын Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын яамнаас Засгийн газарт хүргүүлсэн мэдэгдэлд Төв банк ЖДҮ эрхлэгчид, халдварт өвчнөөс үүдэн үйл ажиллагаа доголдсон тариаланч, аж ахуй эрхлэгчдэд олгох зээлийн хүүг бууруулах, зээл эргэн төлөлтийн хугацааг сунгах зэрэг зээл олголтыг дэмжих үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх шаардлагатай талаар дурджээ. Мөн Сангийн яам зарим доголдсон бизнесүүдийн татвар төлөлт болон газрын түрээсийн төлбөрийг хойшлуулах, татварыг бууруулах асуудлыг авч үзэх талаар мэдэгдсэн.

**Халдварт өвчин гарах үед хариу арга хэмжээ авч ажиллах талаар Англи улсын туршлага**

Англи улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд 2006 онд зургаан долоо хоногийн хугацаанд зах зээлийг бүхэлд нь хамарсан тахал тархахад санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах үүднээс ямар арга хэмжээ авч ажиллах, одоогийн мөрдөгдөж буй зарчмыг хэрхэн сайжруулах тал дээр хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулж байв. Тус уулзалтын үр дүнд дараах санаачилгуудыг гарган, хэрэгжүүлсэн.

- 2007 онд Английн Засгийн газраас “Томуу, томуу төст өвчин, тахлын үеийн хариу арга хэмжээ авах үндэсний хэмжээний стратеги”-ийг баталсан;
- Бэлэн мөнгөний гүйлгээ хийдэг байгууллагууд тахал өвчний үед баримтлах ёс зүйн дүрмийг боловсруулсан;

- Томуу, тахал өвчний үед банкны хэвийн үйл ажиллагааг хангахын тулд жижиглэн худалдааны банкууд зарчимд суурилсан тогтолцоог бий болгосон. Тус тогтолцооны хүрээнд дараах зарчмуудыг баримталсан. Үүнд:

- ажилтнуудыг аюулаас хамгаалах;
- Засгийн газрын үндсэн чиглэлтэй уялдаж ажиллах;
- хамтын ажиллагааны хүрээг идэвхжүүлэх;
- зарчмуудыг сурталчлах.

Эдгээр зарчмуудыг Санхүүгийн зохицуулагч байгууллага, Сангийн яам болон Төв банк нь баталсан бөгөөд Английн бусад санхүүгийн байгууллагуудад өргөн хүрээнд хүлээн зөвшөөрүүлэх талаас нь түгээн дэлгэрүүлэх ажил хийгдсэн.

- Санхүүгийн байгууллагууд болох Лондонгийн хөрөнгийн бирж, Лондонгийн төлбөр тооцооны төв онцгой нөхцөл байдалд ажиллах төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулж илүү боловсронгуй болгосон;
- Салбарын хэмжээг хамарсан асуудлыг шийдэх, мөн гишүүнчлэлээр дамжуулан туршлага солилцох үүднээс даатгалын компаниуд Даатгагчдын холбооны удирдлага дор бизнесийн тогтвортой үйл ажиллагааг хангах холбоог байгуулсан;
- Алслагдсан байршлаас ажиллах групп нь өөр өөр байршлаас ажиллах эрсдэлийг тооцоолох үүднээс байгуулагдсан бөгөөд гол саад бэрхшээлүүдийн талаар удирдамж гаргасан.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

2020 оны эхээр тархсан шинэ төрлийн корона вирус, түүний халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор улс орнуудын хэрэгжүүлж буй хорио цээрийн бодлого нь дэлхийн эдийн засагт нийлүүлэлт болон эрэлт талын шокыг үүсгэн олон улсын санхүүгийн зах зээлийн үзүүлэлтүүд огцом уналтад өртөөд байна. Халдварт өвчнөөс үүдэлтэй энэ удаагийн хямралыг 2009 оны санхүүгийн хямралаас ч илүү гүнзгий байж болзошгүй гэж эдийн засагч, судлаачид таамаглаж байна.

Халдварт өвчний тархалт, хөл хорионоос шалтгаалан манай улсын санхүүгийн салбарт үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, хямралын эсрэг улс орнуудын хэрэгжүүлж буй арга хэмжээнээс суралцах, хүлээгдэж буй эрсдэлээс урьдчилан сэргийлэх

бодлогын саналыг боловсруулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэлээ. Халдварт өвчин тархаад нэг сар гаруй хугацаа өнгөрч, олон улсын санхүүгийн зах зээлүүдэд сөрөг нөлөө гарч эхэлсэн хэдий ч манай улсын санхүүгийн зах зээлийн хувьд вирусийн тархалтаас шалтгаалсан бууралт ажиглагдахгүй байна. Үүнд зах зээлийн суурь хүчин зүйлс болон цаг хугацааны хоцрогдол нөлөөлж байж болох юм.

Судалгааны үр дүнд СЗХ-ноос шууд хэрэгжүүлж болох дараах арга хэмжээний саналыг боловсрууллаа. Үүнд:

- o ББСБ-уудыг зээлийн хүүгээ одоогийн хүүгийн орлогоос зээлийн хүүгийн зардал, зайлшгүй гарах зардал болон алдагдсан боломжийн зардал, зээлийн эрсдэлийн зардлыг хассан зөрүүгээр зээлийн хүүгийн шимтгэлийг бууруулахыг мэргэжлийн холбоодтой хамтран уриалах;
- o Зээлийн хүүгийн хэмжээг бууруулсан ч давагдашгүй хүчин зүйлийн улмаас зээлийн эргэн төлөлт, хүү хугацаандаа төлөгдөхгүй болсон үед гэрээ байгуулагч талууд харилцан тохиролцож, хугацааг хойшлуулах;
- o “Активыг ангилах, активын эрсдэлийн санг байгуулж, зарцуулах журам”-ын зээлийн ангилалд түр хугацаанд өөрчлөлт оруулах;
- o ББСБ болон ХЗХ-дод зайлшгүй гарах зардлаас бусад зардлыг танахыг уриалах;
- o Зохицуулалтын байгууллагуудаас “жил бүр төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлс”-ийг төлөх хугацааг хойшлуулах;
- o ХЗХ-дыг бүх гишүүдийнхээ хурлаараа зээл болон хадгаламжийн хүүгийн хувьдаа өөрчлөлт оруулахыг уриалах;
- o Хорооноос ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх шийдвэрийг хойшлуулах;
- o Үнэт цаас гаргаж буй компани үнэт цаасаа олон нийтэд сурталчлах ажиллагааг олон хүн цуглуулахгүйгээр цахим байдлаар хийж, үнэт цаасны танилцуулгаа танилцуулах чиглэлд технологийн шийдлийг ашиглах талаар андреррайтерд зөвлөх, шаардлагатай гэж үзвэл гадаадын хөрөнгө оруулагчид үнэт цаасны дансаа цахимаар нээх, номинал дансаар дамжуулан харилцагчийн мөнгөн хөрөнгийн гүйлгээг хийх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлд анхаарал хандуулан ажиллах;

- o Хувьцаа эзэмшигчид ногдол ашгаа авахдаа брокерын компанидаа мөнгө хүсэх өргөдлөө өөрийн биеэр очин гаргаж дансаа баталгаажуулж байгааг, харин үнэт цаасны дансгүй иргэд дансаа мөн адил брокерын компани дээр очих байдлаар нээлгэж байгааг хялбарчлах, цаг хугацаа хэмнэсэн, чирэгдэл учруулахгүйгээр зохион байгуулах талаар “ҮЦТХТ” ХХК, МҮЦАЭХ болон бусад үнэт цаасны компаниудтай хамтран ажиллах;
- o Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр хуралдуулах, ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах чиглэлийг барьж ажиллахыг хувьцаат компаниудад зөвлөх, ингэхдээ цахимаар хурал хийхэд санал хураах, санал тоолох ажиллагаанд элдэв сонирхлын зөрчил үүсэх, хууль бус үйлдэл гаргахгүй байх асуудлаар тодорхой чиглэлүүдийг зөвлөмжид тусгах;
- o Үнэт цаасны дараа төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчим нэвтрүүлэх төлөвлөгөөний дагуу олон нийтийг хамарсан ажлуудыг хийж гүйцэтгэхдээ нэг дор бүх үнэт цаасны компаниудын төлөөллийг цуглуулахаас татгалзаж харин хэсэгчилсэн байдлаар зохион байгуулж ажиллахыг дэд бүтцийн байгууллауд болон МҮЦАЭХ-нд чиглэл болгох, төлөвлөгөөний гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажиллах.
- o Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс

тохиолдсон үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бэлэн байдлын стратегийг боловсруулах, хямралыг даван туулах сан байгуулах.

### ЭХ СУРВАЛЖ

- [1] Bank of England, FSA, HM Treasury, Market wide pandemic exercise 2006 progress report, May 2008
- [2] Bank of England, FSA, HM Treasury, Overview of financial sector pandemic flu planning
- [3] Chad Bray and Enoch Yiu, Hong Kong banks to offer relief on mortgages, credit cards, corporate loans as coronavirus outbreak weighs on economy [мэдээ]. (2020.02.06) <https://www.scmp.com/business/banking-finance/article/3049396/hong-kong-banks-offer-relief-mortgages-credit-cards>
- [4] Chinese regions unveil credit support for virus-hit firms [мэдээ]. (2020.01.31) <https://www.aljazeera.com/ajimpact/chinese-regions-unveil-credit-support-virus-hit-firms-200131152444861.html>
- [5] Hong Kong offers cash handouts to ease coronavirus impact [мэдээ]. <https://www.ft.com/content/e170894c-5866-11ea-a528-dd0f971feb9c>
- [6] Liu, HaiYue, et al. “The COVID-19 outbreak and affected countries stock markets response.” International Journal of

Environmental Research and Public Health 17.8 (2020): 2800.

- [7] Travel Insurance Coverage & Coronavirus Trip Cancellations Explained [мэдээ]. (2020.02.28) <https://www.schengenvisainfo.com/news/travel-insurance-coverage-coronavirus-trip-cancellations-explained/>
- [8] Vietnam needs stimulus package to alleviate coronavirus impact, ministry says [мэдээ]. (2020.02.12) <https://www.reuters.com/article/us-china-health-vietnam/vietnam-needs-stimulus-package-to-alleviate-coronavirus-impact-ministry-says-idUSKBN2061DX>
- [9] World bank, Global economic prospects (June 2020) <https://www.worldbank.org/en/publication/global-economic-prospects>
- [10] Zoey Zhang, As Coronavirus Hampers Business Activity, China Seeks to Ease Financial Pressure [мэдээ]. (2020.02.05) <https://www.china-briefing.com/news/china-ease-financial-pressure-businesses-coronavirus-outbreak/>
- [11] Иргэний хууль
- [12] Монголын хөрөнгийн бирж [www.mse.mn](http://www.mse.mn)
- [13] Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль

## ӨРГӨН ДУРАН

## ОЛОН УЛСЫН ДААТГАЛЫН ЗОХИЦУУЛАГЧДЫН ХОЛБООНЫ ХУРАЛ БОЛЛОО



Олон улсын даатгалын зохицуулагчдын холбоо /ОУДЗХ/-ны 27 дахь удаагийн жилийн тайлангийн хурал 2020 оны 12 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд цахим хэлбэрээр боллоо. Хурлыг нээж холбооны Ажлын албаны дарга Вики Сапорта хэлсэн үгэндээ “Холбоо КОВИД-19 цар тахлын хор уршгийг ажралгүй 2020 онд ажлаа үе шаттайгаар амжилттай биелүүлж чадсан. Цаашид ч төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэхэд бэлэн тул халдварт цар тахлын нөлөөгөөр үүсэж болзошгүй нөхцөл байдлыг тогтмол үнэлэх, гол шинэчлэлүүдийг эцэслэн хэрэгжүүлж, гишүүддээ уур амьсгалын өөрчлөлт, дижитал шилжилт зэрэг өөрчлөлт, хөгжлийн чиг хандлагуудад хариу арга хэмжээ авахад нь бид дэмжлэг үзүүлэх болно” гэдгийг онцолсон юм.

Энэ удаагийн хурлаар КОВИД-19 цар тахлын улмаас олон улсын даатгалын салбарт үүсээд буй нөхцөл байдал, цаашид учирч болзошгүй эрсдэл, хямралыг хэрхэн даван туулах талаар санал солилцсоны сацуу 2021 оны үйл ажиллагааны чиглэл болон даатгалын салбарт нөлөөлж буй гол, гол хүчин зүйлсийн талаар хэлэлцжээ. Мөн даатгалын салбар дахь уур амьсгалын эрсдэлийн менежмент (climate risk management), даатгалын болон хохирлын үнэлгээний зөрүү (insurance protection gap)-г бууруулах сэдвээр салбар хуралдаанууд боллоо.

Түүнчлэн “Даатгалын салбар дахь системийн эрсдэлийн нэгдмэл тогтолцоо”-ны үндсэн хэсэг болох “Олон улсын хяналтын хэрэгжүүлэлт”-ийн тоон болон чанарын өгөгдөлд дүн шинжилгээ хийж, дараах үндсэн 4 чиглэлийг тодорхойлжээ. Үүнд:

- Эрсдэлийн үнэлгээ ба санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах (“КОВИД-19” цар тахлын нөлөөллөөс үүсэж болзошгүй нөхцөл байдлын үнэлгээг тогтмол хийх);

- Хямралын дараах шинэчлэлүүд (Даатгалын хөрөнгийн стандартыг боловсронгуй болгох, “Даатгалын салбар дахь системийн эрсдэлийн нэгдмэл тогтолцоог” тууштай хэрэгжүүлэх)-ийг танилцуулах;
- Дэвшилтэт технологи, түүний эрсдэл ба боломжуудыг үнэлэх (технологийн шинэчлэл, кибер эрсдэл, уур амьсгалын эрсдэл зэргийг харгалзан үзэх, хөгжиж буй орнуудыг эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоонд шилжихэд нь дэмжлэг үзүүлэх);
- Даатгалын зохицуулагчдад холбооны стандартыг ойлгож хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, гишүүдэд зориулсан хөтөлбөрийн хэрэгжүүлэлтийг үнэлэх, батлах;

Гишүүд энэ удаагийн хурлыг салбарын зохицуулагч, оролцогчдод холбооны үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, харилцан мэдээлэл, туршлага солилцсон өгөөж өндөртэй хурал боллоо хэмээн дүгнэсэн байна.

Дашрамд сонирхуулахад, байгаль орчныг сайжруулах талаар холбооны баримтлах бодлогыг цахим хурлын өмнөх өдөр танилцуулсан байна. Тодруулбал, хүлэмжийн хийг бууруулах зорилт, явцыг хэмжих арга техникийн талаар бодлогод тусгажээ. Холбооны 2040 он хүртэлх хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөнд багтсан гол ажлын нэг нь мөн “Уур амьсгалын эрсдэл ба тогтвортой байдал” юм. Иймээс НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс байгуулсан Sustainable Insurance Forum буюу даатгалын салбарт тулгарч буй тогтвортой байдлын асуудлаар хамтран ажилладаг даатгалын зохицуулагчдын сүлжээтэй хамтарч хийх ажлууд энд багтжээ.

## САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

### САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫН АЧ ХОЛБОГДОЛ



Сүүлийн жилүүдэд банк, санхүүгийн салбарын өсөлт хурдсаж, хүн амын дунд банкны харилцах данс, хадгаламж, зээлийн үйлчилгээ зэрэг энгийн санхүүгийн бүтээгдэхүүнийг хэрэглэх нь эрс нэмэгдсэн. Гэвч иргэд санхүүгийн мэдлэг, бүтээгдэхүүний ойлголт дутмагаас өөрсдийн хэрэгцээнд тохирсныг сонгож, алс ирээдүйг харсан сонголт хийхэд учир дутагдалтай байсаар байна. Энэ нь тухайн өрхийн санхүүгийн байдлаас гадна урт хугацаандаа улс орны санхүү, эдийн засгийн тогтвортой байдалд ч сөргөөр нөлөөлөх нь бий. Хувь хүн өөрийн санхүүгээ зөв төлөвлөж, амьдралынхаа баталгаагаа хангаж чадвал улс орны эдийн засаг ч дагаад тогтвортой байх нөхцөл бүрдэх билээ.

Хүн өнөөдрийн олсон орлогоо өдөрт нь бүгдийг зарцуулах биш маргааш, эсвэл алс хэтэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийх зорилго тавих ёстой. Иймд амьдралын тодорхой зорилготой, түүндээ хүрэх санхүүгийн зорилготой байх нь зайлшгүй чухал юм. Хувь хүн, өрх гэр, компани, улс орон аль аль нь ялгаагүй ямагт үр ашиг муутай хөрөнгө оруулалтаас татгалзаж, ирээдүйн үр ашигтай хөрөнгө оруулалтад тэмүүлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, хувь хүн санхүүгийн шийдвэр гаргахдаа доорх хэдэн зарчмыг баримтлах ёстой. Үүнд, нэгдүгээрт, тооцоотой байх. Олсон орлогоосоо үндсэн зардлаа хангаад, тодорхой хэмжээний ахиу орлоготой буюу ашигтай үлдэх. Хоёрдугаарт, төлөвлөгөөтэй байх. Чиглэсэн зорилго, төлөвлөгөөтэй байх нь

орлого, зарлагаа оновчтой удирдах удирдамж, чиглэл болох юм. Гуравдугаарт, санхүүгийн нөөцийг тасралтгүй, оновчтой бүрдүүлэх. Өөрөөр хэлбэл, өөрийн үндсэн хэрэгцээг хангах хэмжээний орлоготой байх, түүнийг оновчтой бүрдүүлэх билээ. Хувь хүн санхүүгийн дээрх зарчмуудыг мөрдөж, санхүүгээ оновчтой удирдахад санхүүгийн зорилго, төлөвлөгөө хамгийн чухал бөгөөд түүнд тулгуурлан санхүүгийн шийдвэр гаргах ёстой.

Өнөөгийн олж байгаа орлогоосоо хэдийг нь өнөөдөр хэрэглэж, хэдийг ирээдүйдээ зориулан хадгалах нь зохистой талаар гаргах шийдвэр бол хамгийн чухал шийдвэр юм. Нийгэм хувьсан өөрчлөгдөхийн хэрээр санхүүгийн хэрэгцээ, шаардлага ч өөрчлөгдөж байна. Санхүүгийн хувьд сэтгэл хангалуун байх асуудал бол зохион байгуулалт сайтай хүний оновчтой мөнгөний удирдлага болон санхүүгийн зөв төлөвлөлтийн үр дүн байдаг. Хувь хүний санхүүгийн төлөвлөлт хэд хэдэн давуу талтай. Үүнд: амьдралынхаа турш санхүүгийн нөөцийг оновчтой бүрдүүлэх, хуваарилах, хадгалж хамгаалах бололцоог нэмэгдүүлнэ. Мөн санхүүдээ хяналт тавьснаар хэрээс хэтэрсэн өр төлбөр, дампуурал, бусдын хараат болохоос хамгаалж чадна.

Бид цаг үргэлж зарцуулж, хадгалж, хөрөнгө оруулж эсвэл мөнгө зээлдэж байхдаа мөнгөний, цаг хугацааны үнэ цэнийн зэрэгцээ алдагдсан боломжийн өртгийг тооцох хэрэгтэй болдог. Жишээлбэл, Та ямар нэгэн хөрөнгө оруулалт хийх эсвэл худалдан авалт хийх гэж байна уу? Тэгвэл тухайн хөрөнгө оруулалтынхаа ирээдүйн үнэ цэнийг тодорхойлох хэрэгтэй. Ойрын үнэ цэнээр тооцон худалдан авалт хийтэл тодорхой цаг хугацааны дараа таны худалдан авалт үнэ цэнээ алдах магадлалтай. Тиймээс та хөрөнгө оруулалт, худалдан авалтынхаа ирээдүйн үнэ цэнийг маш сайн судлах хэрэгтэй. Тухайлбал, хадгаламжийн данснаасаа мөнгөө авч зарцуулснаар хүүний орлого алдах хэдий ч илүү орлого олох, ашиг хүртэх зүйлд хөрөнгө оруулалт хийвэл өгөөж нь илүү байх болно.

Хүн бүр өөрийн олсон мөнгөн орлогоо оновчтой, үр ашигтай зарцуулах талаар тооцоо, төлөвлөгөөтэй байх ёстой. Өнөөдрийн гаргах санхүүгийн шийдвэрийг зөв тооцож, тодорхойлж гаргахгүй бол үр ашиггүй, ач холбогдолгүй, буруу шийдвэр гаргаж болзошгүй. Өөрөөр хэлбэл, үр өгөөж хүртэхгүй, үрэлгэн зардал гаргаснаар ирээдүйд олж болох ашгаасаа татгалзаж байна гэсэн үг. Хүн бүр өдөр тутам ямар нэг байдлаар санхүүгийн шийдвэр гаргадаг бөгөөд тэдгээрийг дараах байдлаар ангилдаг. Үүнд:

1. Хэрэглэх эсвэл хуримтлуулахтай холбоотой шийдвэр
2. Хөрөнгө оруулалтын шийдвэр
3. Санхүүжилтийн шийдвэр
4. Эрсдэлийг удирдах, бууруулахтай холбоотой шийдвэр

Өнөөгийн олж байгаа орлогоосоо хэчнээнийг өнөөдөр хэрэглэж, хэдийг ирээдүйдээ зориулан хадгалах нь зохистой талаар гаргах шийдвэр бол хамгийн чухал шийдвэр. Хүсэлдээ хөтлөгдөж бус хэрэгцээ шаардлагадаа нийцүүлэн хэрэглэж, тодорхой хэмжээний хуримтлалыг үүсгэх нь зайлшгүй чухал шийдвэр билээ.

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНД АНХААРАХ АСУУДЛУУД

КОВИД-19 цар тахал, арьс өнгөний ялгаварлан гадуурхалт, нийгэм, эдийн засгийн харилцан тэгш бус байдал, дэлхийн уур амьсгалын сөрөг өөрчлөлтүүд, мэдээллийн технологийн шинэчлэл, эдгээрийн үр дүнд илрэх улс төрийн болон хяналт, зохицуулалтын орчны эргэж буцалтгүй, тааварлах боломжгүй цочмог өөрчлөлт зэрэг нь компанийн төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ”/-ийн болон байгууллагын өмнө тулгамдаж буй хүндхэн сорилтууд энэ онд ч хэвээрээ байна. Эдгээр нь тогтвортой байдал, уян хатан чанар болон компанийн зорилгын гол сэдвүүдийг онцолж, бизнесийнхээ эрүүл, урт хугацааны амжилтад чухал нөлөөтэй бусад олон оролцогч талуудын ашиг сонирхлыг удирдан зохицуулахын тулд байгууллагууд хэрхэн ажиллах ёстой талаар цоо шинэ үзэл баримтлалыг бий болгох шаардлагыг үүсгэж байна. Ийм нөхцөлд дэлхий даяар томоохон компанийн ТУЗ-үүд эдгээр бэрхшээлийг даван туулахын тулд өөрийн болон дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, бусад дотоод тогтолцооныхоо үйл ажиллагаа, манлайллын үүргийг оновчтой болгох, мөн оролцогч талуудын хүлээлтийг биелүүлэхийг эрмэлзэж байна.

#### Компанийн зорилго болон стратеги

- Байгууллагын зорилгын талаар маш тодорхой мэдлэг, итгэл үнэмшилтэй байх нь урьд урьдынхаас илүү чухал. BlackRock-ийн ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал Ларри Финкийн ажигласнаар “Зорилгоо маш сайн ухамсарласан компаниуд, мөн хөрөнгө оруулагчид энэ хямрал болон түүний үр дагаврыг илүү сайн даван туулах болно.” Энэ тал дээр өрнөдийн бараг бүх томоохон нээлттэй хувьцаат компаниудын томоохон хөрөнгө оруулагчид адил байр суурьтай байгаагаа илэрхийлэв.
- Байгууллагын зорилго гэдэг нь өргөн утгаараа компани амжилтад хүрэх, урт хугацааны туршид үнэ цэнээ өсгөх зорилгоор хууль ёсны, ёс суртахуунтай, үр ашигтай, тогтвортой бизнес эрхлэхэд чиглэгддэг. Аливаа компани зорилгоо тодорхойлохдоо бизнесийн стратегийг илүү амилуулж байдаг үнэ цэнийг илүү тодотгох замаар болон хувьцаа эзэмшигчид, ажиллагсад, ханган нийлүүлэгчид, үйлчлүүлэгчид, олон нийт гэх мэт оролцогч талуудын эрх ашгийг харгалзан үзэх хэрэгтэй.
- Олон компанийн ТУЗ байгууллагын зорилгыг тодорхойлох, хөгжүүлэхдээ гүйцэтгэх удирдлагатай хэрхэн хамтрах талаар практик удирдамжийг эрэлхийлсээр ирсэн. Үүнтэй холбогдуулан Enacting Purpose Initiative хамтын ажиллагааны байгууллагаас 2020 оны 8 дугаар сард “Орчин цагийн компанийн зорилгыг хэрэгжүүлэх нь” гэсэн тайлан гаргасан бөгөөд энэ нь компаниудын зорилгыг практикт хэрхэн хөрвүүлэх боломжтойг харуулсан загвар бүхий ТУЗ-ийн гарын авлага юм. Энэхүү тайланд компаниуд хэрхэн (1) энгийн бөгөөд оновчтойгоор зорилгоо тодорхойлох, (2) зорилго болон шийдвэр гаргалтыг уялдуулах, (3) тодорхойлсон зорилгыг байгууллагын хэмжээнд хүлээн зөвшөөрөх, дэмжих, (4) тогтоосон зорилгодоо хүрч буй эсэхийг үнэлэх зорилгоор гүйцэтгэлийн хэмжүүрийг тогтоох, (5) урт хугацааны стратеги, бодлогыг ашиглан компанийн зорилго, гүйцэтгэлийг үлгэрлэх, дамжуулах. Одоогийн тайлан нь Европын холбоо, Их Британийн компаниудад зориулагдсан бол АНУ-ын компаниудад зориулсан загварыг 2021 оны хавар олон нийтийн хүртээл болгон гаргахаар төлөвлөж байна.
- Мөн саяхны McKinsey-ийн тайланд ТУЗ нь байгууллагын зорилгыг ажил хэрэг болгохын тулд хийж болох таван арга хэмжээг тодорхойлсон байна: (1) гүйцэтгэх удирдлагын хамт компанийн зорилгыг тодорхойлох болон оролцогч талуудыг үүнд идэвхтэй оролцуулах; (2) ТУЗ өөрөө болон ТУЗ-ийн бүрэлдэхүүн ч өөрсдийн зорилготой байх; (3) зорилгын оновчтой тодорхойлолт болон зорилгын биелэлтийг үнэлэх; (4) стратеги, эрсдэл, гүйцэтгэл болон засаглалын хүрээнд ТУЗ шийдвэр гаргахдаа зорилгоо луужин болгон ашиглах; (5) гүйцэтгэх удирдлагын үнэлгээ, тайлагналаар дамжуулан байгууллага доторх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх.

Үргэлжлэл бий...

Эх сурвалж: Harvard Law School Forum on Corporate Governance



## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### ЕВРОП, ТӨВ АЗИЙН ОРНУУДЫН ҮЙЛ ЯВЦ КОВИД-19-ИЙН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АРГА ХЭМЖЭЭ

КОВИД-19 цар тахлын тархалттай холбоотойгоор Европ, Төв Азийн орнуудын эдийн засгийн идэвхжил 2020 онд 2.9 хувиар буурсан гэсэн тооцоо гарчээ. Цар тахлын улмаас бүс нутгийн эдийн засгийн тавны нэг орчимд нь нэг хүнд ногдох орлогын хэмжээ дор хаяж таван жилээр буурч, ядуурлын түвшин нэмэгдэх төлөвтэй байгаа юм. Евро бүстэй худалдаа, санхүүгийн байдлаараа холбоо хамааралтай улс орнууд хамгийн ихээр нэрвэгджээ. Цаашид хэтийн төлөв нь тодорхойгүй хэвээр байгаа бөгөөд хэрэв цар тахал удаан үргэлжилж, гадаад санхүүжилтийн нөхцөл байдал муудах, эсвэл геополитикийн хурцадмал байдал дахин даамжирвал эдийн засгийн өсөлт удаашрах болно.

#### Эдийн засаг дахь сүүлийн үеийн өөрчлөлт

КОВИД-19 цар тахал нь Европ, Төв Азид эрүүл мэнд, эдийн засгийн томоохон хямралыг бий болгож, улмаар нийгмийн эмх замбараагүй байдал улам бүр нэмэгдлээ. Эдгээр бүс нутгийн 9.5 сая хүн КОВИД-19 халдвараар өвчилсөн ба нэг хүнд ногдох дотоодын нийт бүтэгдэхүүн /цаашид “ДНБ” гэх/-ий хэмжээ нь мөн хамгийн их бууралттай бүс нутаг болжээ. 2020 оны 4 дүгээр улирлаас эхлэн шинэ тохиолдлын тоо огцом өссөнөөр Засгийн газруудаас тохиолдлын тоог бууруулах арга хэмжээ авахаар хурдацтай ажиллах болов. Бүс нутгийн ДНБ 2020 онд 2.9 хувиар буурсан гэж тооцоолж байгаа бөгөөд бараг бүх эдийн засаг уналтад орж, гуравны хоёр нь дэлхийн санхүүгийн хямралын үеэс илүү гүнзгий хямралд орох төлөвтэй байна. Европ, Төв Азийн эдийн засгийн гарц нь оны эхний хагаст цар тахлын шинжтэй холбоотой хязгаарлалтаар огцом буурсан нь дотоодын эрэлт, үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа буурахад нөлөөлжээ. Дэлхийн худалдааны сул байдал нь бүс нутгийн экспортыг бууруулж байгаагаас жуулчид ирэх нь багассан байна. Европ дахь ажлын байрны хомсдол, ОХУ дахь нефтийн үнийн уналтын нөлөөлөл нь мөнгөн гуйвуулгын урсгалд ихээхэн нөлөөлөв. Гэсэн хэдий ч, ялангуяа дотоодын дэгдэлтийг хурдан хугацаанд хянаж байсан орнуудын аж үйлдвэрлэл, жижиглэнгийн борлуулалт зэрэг үзүүлэлтүүд нь 2020 оны 3-р улиралд хязгаарлалт аажмаар буурахад сайжирч эхэлсэн байна.

Цар тахлын гамшигт хамгийн их нэрвэгдсэн эдийн засаг бол Евро бүстэй худалдаа, санхүүгийн нарийн холбоотой улсууд болон үйлчилгээ, аялал жуулчлалаас ихээхэн хамааралтай улсууд юм. Нийтдээ энэ цар тахлын улмаас бүс нутагт 3.20 ам.долларын хязгаартай ядуурлын шугамд 2.2 сая хүн нэмэгдэж, зарим улс орнууд, ялангуяа Төв Азийн айл өрхүүдийн дунд хийсэн судалгаагаар хүнсний дутагдал ихэссээр байгааг мэдээлж байна. Европ, Төв Азийн шинээр гарч ирж буй зах зээл болон хөгжиж буй эдийн засаг нь цар тахлын эхний үеэс эхлэн төсвийн багцаас илүү их мөнгийг зарцуулж байсан нь хөрөнгө оруулагчдын итгэлийг алдаж буйг харуулав. Эдгээр гадагш урсгал нь валютын ханшийн бууралт, нөөцийн алдагдлыг дахин сэргээсэн байна. Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр өндөртэй эдийн засагтай орнуудад болон гадаад хөрөнгө оруулагчид орон нутгийн үнэт цаасны зах зээлийн томоохон хувийг эзэлдэг орнуудад зээлийн хүү хамгийн их өссөн байна. Гадаад эрэлтийн уналтаас үүдэлтэй экспортын уналт урсгал дансны дарамтыг улам бүр нэмэгдүүлсэн.

Төсвийн дэмжлэгийн багцыг бараг бүх Европ, Төв Азийн эдийн засагт зарласан бөгөөд хэд хэдэн Засгийн газар албан ёсны эх үүсвэрээс тусламж авч, өрийн зах зээл дээрх зээлийг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тогтолцоо болон аюулгүй байдлыг бэхжүүлэн, хувийн хэвшлийг дэмжиж мөн санхүүгийн зах зээлийн бууралттай тэмцэх ажлыг гүйцэтгэв. Ажлын байрыг хадгалах, хөдөлмөрийн зах зээлийг дэмжих схемийг ажил эрхлэлтийг тогтвортой байлгах зорилгоор хэрэгжүүлсэн. Эдгээр арга хэмжээнүүдийг үл харгалзан цар тахлаас үүдсэн Европт 2020 оны эхний гурван улирлын байдлаар 106 сая ажлын байрны ажлын цагын хөлстэй тэнцэх алдагдал хүлээсэн. Ажилгүйчүүдийн тоо өссөн нь Төв Европын зарим улс, ОХУ-д илт ажиглагдаж байв. Европ, Төв Азийн төсвийн хариу арга хэмжээ нь бусад шинээр гарч ирж буй зах зээл болон хөгжиж буй эдийн засгийн бүс нутгуудтай харьцуулбал илүү өндөр байна. 2022 он гэхэд төсвийн хариу арга хэмжээ, бүтээгдэхүүний гарц хумигдсанаар өрийн хэмжээ дунджаар ДНБ-ий 50 хувиас хэтрэхгүй байх төлөвтэй байгаа нь 2019 оныхоос ойролцоогоор 8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эдийн засгийн нөхцөл байдал муудахын хэрээр мөнгөний бодлого улам чангарч байна. Хэд хэдэн төв банкууд валютаа тогтворжуулах, хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын зах зээл дээр хөндлөнгөөс оролцсон (Хорват, Казахстан, Киргиз, Серби, Турк), бусад нь бие даасан баялгийн сангуудыг ашигласан байна (Азербайжан, Казахстан). Ялангуяа инфляц зорилтот түвшинтэй ойролцоо буюу түүнээс дээш байгаа орнуудын хувьд сүүлийн үеийн валютын ханшийн сулралт нь инфляцад нөлөөлж, бодлогын хүүг бууруулах шаардлага үүсэж байна. Зарим улс орнууд (Хорват, Унгар, Польш, Румын, Турк) уламжлалт бус бодлого болох актив худалдан авах арга зэргийг ашигласан байна.



## Европ, Төв Азийн орнуудын урьдчилсан мэдээ

(ДНБ-ий бодит өсөлтийг зах зээлийн үнээр тооцвол, хувь)


Улс	2018	2019	2020	2021 (урьдчилсан байдлаар)	2022 (урьдчилсан байдлаар)
Албани	4.1	2.2	-6.7	5.1	4.4
Армени	5.2	7.6	-8.0	3.1	4.5
Азербайжан	1.5	2.2	-5.0	1.9	4.5
Беларусь	3.1	1.2	-1.6	-2.7	0.9
Босни ба Херцеговина	3.7	2.7	-4.0	2.8	3.5
Болгар	3.1	3.7	-5.1	3.3	3.7
Хорват	2.7	2.9	-8.6	5.4	4.2
Гүрж	4.9	5.1	-6.0	4.0	6.0
Унгар	5.1	4.6	-5.9	3.8	4.3
Казахстан	4.1	4.5	-2.5	2.5	3.5
Косово	3.8	4.2	-8.8	3.7	4.9
Киргизстан	3.8	4.5	-8.0	3.8	4.5
Молдав	4.3	3.6	-7.2	3.8	3.7
Монтенегро	5.1	4.1	-14.9	6.1	3.9
Хойд Македон	2.7	3.6	-5.1	3.6	3.5
Польш	5.4	4.5	-3.4	3.5	4.3
Румын	4.4	4.1	-5.0	3.5	4.1
ОХУ	2.5	1.3	-4.0	2.6	3.0
Серби	4.4	4.2	-2.0	3.1	3.4
Тажикистан	7.3	7.5	2.2	3.5	5.5
Турк	3.0	0.9	0.5	4.5	5.0
Украин	3.4	3.2	-5.5	3.0	3.1
Узбекстан	5.4	5.6	0.6	4.3	4.5

# ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2021 оны 02 дугаар сарын 28-ны өдөр

S&P 500 /^GSPC/


**3,811.15** -18.19 (-0.48%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nikkei 225 /^N225/


**28,966.01** -1,202.26 (-3.99%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

FTSE 100 /^FTSE/


**6,483.43** -168.43 (-2.53%)



Эх сурвалж: www.finance.yahoo.com

Nasdaq 100 Dec 20 (NQ=F)

**12,905.75** +74.00 (+0.58%)



Эх сурвалж: www.Bloomberg.com

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160

+976-51-264444

press@frc.mn

www.frc.mn

Санхүүгийн зохицуулах хороо

@FRC\_of\_Mongolia